БАТЛАВ:
ОЮУТНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА Д.ЦОГЗОЛМАА

ШУТИС-ИЙН ОЮУТНЫ САНААЧИЛГААР БИЙ БОЛСОН КЛУБИЙН ЭРХ, ҮҮРЭГ

ШУТИС-ийн оюутнуудыг хөгжүүлэн төлөвшүүлэх, хамтран ажиллах, харилцан суралцахад чиглэсэн сайн дурын үйл ажиллагааг клубийн системээр оюутанд хүргэх нь үр дүнтэй үйл ажиллагаа юм.

- ШУТИС-ийн оюутны сайн дурын болон мэргэжлийн клуб нь оюутны санал санаачилгад тулгуурлан үүсгэн байгуулагдсан байна. Клуб зөвлөх багштай байж болно.
- Клуб нь өөрийн танилцуулга, үйл ажиллагааны зорилго, зорилт хамрах хүрээг тодорхой бичиж ШУТИС-ийн вебд байрлуулсан байна.
- Клубүүд ажлын тайлангаа улирал бүрийн сүүлийн долоо хоногийн баасан гарагт хэлэлцүүлнэ.
- Тайланг үндэслэн дараа улирлын ажлын төлөвлөгөөнд шаардагдах зарим төсвийг холбогдох нэгжүүд, бүрэлдэхүүн сургуулиас авч болно.
- Клубийн ажлын үр дүнг харгалзан клубийн ахлагч, идэвхтэй гишүүд болон оюутан багш нарыг кредитийн урамшуулал олгох журмын дагуу урамшуулна.
- Шинээр байгуулагдсан клубийн ажлын үр дүнг харгалзан батламж олгоно.
- Клубийн гишүүнчлэлийг нээлттэй болон хаалттай хэлбэрээр авч болно.

КЛУБИЙН ЭРХ:

Үйл ажиллагааг клуб дангаараа болон бусад клубүүдтэй хамтран зохион байгуулах
Клуб өөрийн үйл ажиллагааны чиглэлээр их сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, санал дэвшүүлэх
Клуб нь их сургуулийн аль нэг анги эзэмших болон хамтран эзэмших
Клуб өөрийн үйл ажиллагааны хүрээнд их, дээд сургууль болон улс, олон улсын хэмжээнд тэмцээн уралдаан зохион байгуулах
Клуб өөрийн үйл ажиллагаанд зөвлөгөө авах мэргэжлийн зөвлөх багш болон бусад алба нэгжтэй хамтран ажиллах
Клуб төсөл хөтөлбөрт хамрагдах, Эрдэм шинжилгээний хурал, бүтээлийн үзэсгэлэн бусад уралдаан тэмцээнд оролцох

КЛУБИЙН ҮҮРЭГ:

Клуб нь гишүүдээ ШУТИС-ийн нэгдсэн арга хэмжээ, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах
Клубүүдийн дунд зохион байгуулж буй нэгдсэн арга хэмжээнд тогтмол оролцох
Тайлангаа цаг хугацаандаа хэлэлцүүлэн дүгнүүлэх
ШУТИС болон бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд оюутанд чиглэсэн нэгээс хоёр шинэлэг ажлыг санаачилан хэрэгжүүлэх.

ОЮУТНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА